



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА/2025/157/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Улиастай сум	Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: boldbaatar@audit.gov.mn
2025 он	Ахлах аудитор: Б.Жалбаа Утас: 89330330 Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81000 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Н.ОТГОНЖАРГАЛ-Д

2025.08.10 № 46

таныг _____ ны № _____

ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдсан байгууллагын эзэмшлийн газарт дахин үнэлгээ хийж 160.8 сая төгрөгөөр өртгийг бууруулсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар санхүүгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн алдаа илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд Цагдаагийн байгууллагын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай

D:/disk/Албан бичиг/Дүгнэлт-2025

01 08 25

хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	368,346,057.87	388,102,226.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	51,785,128.77	68,015,393.70
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	51,785,128.77	68,015,393.70
3121	Төгрөг	51,785,128.77	68,015,393.70
35	БАРАА МАТЕРИАЛ	316,560,929.10	320,086,832.90
351	Түүхий эд материал	191,201,054.91	190,667,053.71
35110	Тусгай зориулалттай материал	189,725,461.91	189,832,193.71
35130	Эм боох материал	1,475,593.00	834,860.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	3,361,450.00	3,361,450.00
354	Хангамжийн материал	121,998,424.19	126,058,329.19
35410	Бичиг хэргийн материал	8,841,300.91	9,789,426.41
35420	Аж ахуйн материал	21,905,244.28	22,075,245.78
35440	Түлш, шатах тослох материал	23,448,492.00	22,415,000.00
35450	Барилгын засварын материал	11,649,227.00	13,620,627.00
35460	Хүнсний материал	845,240.00	903,240.00
35470	Бусад хангамжийн материал	55,308,920.00	57,254,790.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,753,462,618.62	5,647,028,230.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,753,462,618.62	5,647,028,230.69
392	Биет хөрөнгө	5,264,351,267.02	5,318,723,379.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,343,497,081.00	5,387,811,281.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-958,350,885.54	-1,174,027,321.82
39203	Авто-тээврийн хэрэгсэл	603,741,325.10	1,002,809,949.62
39204	Хуримтлагдсан элэгдэл	-269,579,296.16	-443,294,112.23
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	579,386,843.64	772,193,249.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-181,139,464.41	-341,678,594.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	103,145,830.62	91,911,108.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	-43,268,679.70	-53,209,373.25
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	57,264,807.00	57,264,807.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,576,700.00	38,576,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,922,994.53	-19,634,314.61
393	Биет бус хөрөнгө	489,111,351.60	328,304,851.60
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	489,111,351.60	328,304,851.60
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,121,808,676.49	6,035,130,457.29
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,121,808,676.49	6,035,130,457.29
51	Засгийн газрын хувь оролцоо	6,121,808,676.49	6,035,130,457.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,133,884,592.84	2,133,884,592.84
51101	Өмч: - төрийн	2,133,884,592.84	2,133,884,592.84
512	Хуримтлагдсан үр дүн	2,400,948,901.02	2,314,270,681.82
51210	Өмнөх үеийн үр дүн	2,400,948,901.02	2,240,142,401.02
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	74,128,280.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,586,975,182.63	1,586,975,182.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,121,808,676.49	6,035,130,457.29

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,775,597,972.64	9,203,165,694.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	450,437,147.64	709,717,154.02
120	Нийтлэг татварын бус орлого	450,437,147.64	709,717,154.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	262,731,197.00	186,679,568.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	78,277,075.00	135,041,323.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	184,454,122.00	51,638,245.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,325,160,825.00	8,493,448,540.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,092,336,200.00	8,109,979,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,092,336,200.00	8,109,979,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	232,824,625.00	383,469,340.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,749,000.00	250,993,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	111,232,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	197,075,625.00	21,244,340.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,797,804,359.15	9,129,037,413.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,797,284,359.15	9,128,413,413.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,220,430,570.21	7,820,910,464.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,973,393,096.81	6,249,736,618.15
210101	Үндсэн цалин	2,718,099,908.21	3,419,596,279.13
210102	Нэмэгдэл	1,907,323,953.60	2,275,036,587.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,936,000.00	112,518,943.00
210104	Урамшуулал	189,249,835.00	367,609,265.00
210105	Гэрээт ажлын хөлс	82,783,400.00	74,975,543.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,964,180.14	158,667,200.00
210201	Тэтгэврийн даатгал	8,211,884.49	5,791,382.39
210202	Тэтгэмжийн даатгал	966,103.94	371,452.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	772,883.18	124,074.01
210204	Ажилгүйдлийн даатгал	194,378.26	185,726.15
210205	Эрүүл мэндийн даатгал	101,818,930.27	152,194,565.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,059,191.19	217,472,577.00
210301	Гэрэл, цахилгаан	52,854,377.19	68,549,600.00
210302	Түлш, халаалт	138,458,774.00	128,044,777.00
210303	Цэвэр, бохир ус	13,746,040.00	20,878,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	274,474,946.49	306,372,953.00

210401	Бичиг хэрэг	31,394,900.00	35,597,290.00
210402	Тээвэр, шатахуун	199,574,090.00	191,423,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,589,066.49	51,540,512.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	303,600.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,613,290.00	13,458,198.50
210408	Бараа материал акталсны зардал	00.00	13,953,952.00
2105	Нормативт зардал	37,056,390.31	113,440,183.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	865,558.50	2,110,733.00
210502	Хоол, хүнс	30,275,831.81	98,001,450.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,915,000.00	13,328,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	83,778,600.00	105,582,560.00
210604	Урсгал засвар	83,778,600.00	105,582,560.00
2107	Томилолт, зочны зардал	21,606,400.00	29,925,700.00
210702	Дотоод албан томилолт	21,606,400.00	29,925,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,601,627.00	44,066,938.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,755,700.00	41,283,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	894,860.00	894,176.72
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	388,000.00	298,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	1,320,000.00
210807	Газрын төлбөр	269,642.00	121,392.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	293,425.00	149,820.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	480,496,138.27	595,645,734.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	304,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,791,080.48	13,523,916.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хэрогдол	467,705,057.79	581,817,118.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	576,853,788.94	1,307,502,948.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	555,438,613.94	1,293,502,048.20
213204	Ажил олгогчсоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,571,250.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	310,079,588.00	588,076,445.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	86,610,800.00	548,138,468.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	151,176,975.94	157,287,135.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,415,175.00	14,000,900.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,055,175.00	12,141,323.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	520,000.00	624,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	520,000.00	624,000.00
225102	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/	520,000.00	624,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-22,206,386.51	74,128,280.80
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-22,206,386.51	74,128,280.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	6,442,505,547.62	8,671,186,127.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	117,344,722.62	177,737,587.93
120	Нийтлэг татварын бус орлого	117,344,722.62	177,737,587.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	117,344,722.62	177,737,587.93
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	78,277,075.00	135,041,323.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,067,647.62	42,696,264.93
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,325,160,825.00	8,493,448,540.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	6,092,336,200.00	8,109,979,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	6,092,336,200.00	8,109,979,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	232,824,625.00	383,469,340.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,749,000.00	250,993,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	111,232,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	197,075,625.00	21,244,340.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,350,835,900.00	8,575,751,783.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,350,835,900.00	8,575,751,783.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,770,763,225.00	7,265,482,282.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,003,562,400.00	6,284,340,700.00
210101	Үндсэн цалин	2,748,269,211.40	3,258,565,753.23
210102	Нэмэгдэл	1,907,323,953.60	2,356,646,519.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,936,000.00	112,518,943.00
210104	Урамшуулал	189,249,835.00	458,765,504.24
210105	Гэрээт ажлын хөлс	82,783,400.00	97,843,980.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,087,300.00	158,667,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	112,087,300.00	158,667,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,469,677.19	206,010,800.00
210301	Гэрэл, цахилгаан	52,854,377.19	68,549,600.00
210302	Түлш, халаалт	137,532,400.00	116,583,000.00
210303	Цэвэр, бохир ус	15,082,900.00	20,878,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	266,430,101.00	294,115,352.50
210401	Бичиг хэрэг	21,387,200.00	35,742,100.00
210402	Тээвэр, шатахуун	201,276,300.00	195,467,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,143,821.00	52,206,012.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	303,600.00	400,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,319,180.00	10,300,000.00
2105	Нормативт зардал	29,183,326.81	109,361,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	180,000.00	1,470,000.00
210502	Хоол, хүнс	24,603,326.81	96,563,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,400,000.00	11,328,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,182,900.00	119,693,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,638,100.00	8,479,920.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	68,544,800.00	109,213,960.00
2107	Томилолт, зочны зардал	21,646,100.00	30,013,800.00
210702	Дотоод албан томилолт	21,646,100.00	30,013,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,182,100.00	49,570,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,628,000.00	46,933,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	895,300.00	895,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	388,800.00	300,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,000,000.00	1,320,000.00
210807	Газрын төлбөр	270,000.00	121,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,019,320.00	13,708,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,019,320.00	13,708,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	580,072,675.00	1,310,269,500.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	558,657,500.00	1,296,268,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,750,000.00	1,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	310,079,700.00	588,076,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	86,610,800.00	548,139,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	153,217,000.00	158,552,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,415,175.00	14,000,900.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,055,175.00	12,141,323.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>91,669,647.62</u>	<u>95,434,344.93</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	67,672,000.00	79,204,080.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	67,672,000.00	79,204,080.00
2200	Дотоод эх үүсвэрээр	67,672,000.00	79,204,080.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	67,672,000.00	79,204,080.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-67,672,000.00</u>	<u>-79,204,080.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	23,997,647.62	16,230,264.93
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,787,481.15	51,785,128.77
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	51,785,128.77	68,015,393.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,124,980,592.84	1,593,672,239.63	2,337,757,921.31	6,056,410,753.78
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,124,980,592.84	1,593,672,239.63	2,337,757,921.31	6,056,410,753.78
C07	Тайлант үеийн үр дүн	964,000.00	00.00	78,700,309.22	79,664,309.22
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,133,884,592.84	1,586,975,182.63	2,400,948,901.02	6,121,808,676.49
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,133,884,592.84	1,586,975,182.63	2,400,948,901.02	6,121,808,676.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-160,806,500.00	-160,806,500.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,133,884,592.84	1,586,975,182.63	2,240,142,401.02	5,961,002,176.49
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	74,128,280.80	74,128,280.80
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,133,884,592.84	1,586,975,182.63	2,314,270,681.82	6,035,130,457.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,232,879,400.00	8,245,020,523.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,232,879,400.00	8,245,020,523.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,983,076,800.00	6,983,076,600.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,237,200,700.00	6,237,200,700.00
210101	Үндсэн цалин	3,234,827,400.00	3,211,425,753.23
210102	Нэмэгдэл	2,334,680,500.00	2,356,646,519.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,080,000.00	112,518,943.00
210104	Урамшуулал	520,000,000.00	458,765,504.24
210105	Гэрээт ажлын хөлс	97,612,800.00	97,843,980.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,135,400.00	148,135,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	148,135,400.00	148,135,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	206,010,800.00	206,010,800.00
210301	Гэрэл, цахилгаан	68,549,600.00	68,549,600.00
210302	Түлш, халаалт	116,583,000.00	116,583,000.00
210303	Цэвэр, бохир ус	20,878,200.00	20,878,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	219,867,200.00	219,867,200.00

210401	Бичиг хэрэг	20,748,300.00	20,748,300.00
210402	Тээвэр, шатахуун	179,808,200.00	179,808,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,610,700.00	9,610,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,300,000.00	9,300,000.00
2105	Нормативт зардал	14,895,900.00	14,895,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	300,000.00	300,000.00
210502	Хоол, хүнс	13,095,900.00	13,095,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,165,400.00	100,165,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,500,000.00	14,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	83,665,400.00	83,665,400.00
2107	Томилолт, зочны зардал	29,563,800.00	29,563,800.00
210702	Дотоод албан томилолт	29,563,800.00	29,563,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,737,600.00	24,737,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,100,000.00	22,100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	895,300.00	895,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,800.00	300,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,000.00	1,320,000.00
210807	Газрын төлбөр	121,500.00	121,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2500000.00	2500000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1249802600.00	1249802600.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,249,802,600.00	1,249,802,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	1,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	588,076,500.00	588,076,500.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	548,139,300.00	548,139,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	112,086,800.00	112,086,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,232,879,400.00	8,245,020,523.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	8,109,979,400.00	8,109,979,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	8,109,979,400.00	8,109,979,200.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	122,900,000.00	135,041,323.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	122,900,000.00	135,041,323.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	216.00	198.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	197.00	180.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	11.00
620004	Гэрээт ажилтан	04.00	04.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	383,469,340.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	383,469,340.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	361,609,762.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47,140,000.00
210101	* Үндсэн цалин	47,140,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,532,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,532,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74,248,152.50
210401	Бичиг хэрэг	14,993,800.00
210402	Тээвэр, шатахуун	15,659,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	42,595,312.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00
2105	Нормативт зардал	94,466,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,170,000.00
210502	Хоол, хүнс	83,468,000.00
210503	* Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,828,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	98,732,560.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	73,184,000.00
210604	Урсгал засвар	25,548,560.00
2107	Томилолт, зочны зардал	450,000.00
210702	Дотоод албан томилолт	450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,833,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,833,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11208000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,208,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20000000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,859,577.50
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,859,577.50
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	383469340.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	383,469,340.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,993,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	111,232,000.00
131105	* Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,244,340.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба юм.

Тус байгууллага нь 2024 онд 5 зорилтын хүрээнд 47 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж, биелэлт 98.08 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Цагдаагийн газар нь үйл ажиллагаандаа Цагдаагийн албаны тухай, Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

НББ-ын бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 86.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	51,785.1	68,015.4	16,230.3
Авлага	0	0	0
Бараа материал	316,560.9	320,086.8	3,525.9
Үндсэн хөрөнгө	5,753,462.6	5,647,028.3	-106,434.3
Нийт хөрөнгө	6,121,808.6	6,035,130.5	-86,678.1
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,121,808.6	6,035,130.5	-86,678.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,121,808.6	6,035,130.5	-86,678.1

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

- ✓ Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 16.2 сая төгрөгөө өссөн нь ахмадын сангийн үлдэгдэл нэмэгдсэнтэй
- ✓ Үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь байгууллагын эзэмшилд буй газарт дахин үнэлгээ хийлгүүлж төсөвт өртгийг 160.8 сая төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төслийг хуулийн хугацаанд боловсруулан дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны зардал, Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, байцаан шийтгэх ажиллагаа гэсэн 3 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,232.9 сая төгрөгийг баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 8,110.0 сая төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагаанаас 135.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж өөрийн орлогын төлөвлөгөөг 12.1 сая төгрөгөөр давуулан биелүүлж тайлант оны эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	6,976,476.8	6,976,476.8	0	100
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,249,802.6	1,249,802.6	0	100
3	Байцаан шийтгэх ажиллагаа	6,600.0	6,600.0	0	100
	ДҮН	8,232,879.4	8,232,879.4	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 383.5 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн ГХУСАЗСЗ-ийн санхүүжилт 73.2 сая төгрөг
- Олон нийтийн цагдаагийн цалин, урамшуулал 67.5 сая төгрөг
- Аймгийн Засаг даргын шийдвэрээр олгосон 56.8 сая төгрөг
- Аймгийн ОНХС-аас олгосон 49.5 сая төгрөг
- Улиастай сумын Засаг даргын шийдвэрээр олгосон 4.0 сая төгрөг
- Улс орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбоотой олгосон 111.2
- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлого 21.3 сая төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тусгайлан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 41/314 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн тайлангийн нийт зардлаар сонгож 9,130.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 136.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Цагдаагийн газрын шилэн дансны мэдээллийг анхан шатны баримттай тулган шалгахад алдаа зөрчил илрээгүй болно.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Цагдаагийн газрын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийхээр төлөвлөсөн ч ажлын ачааллын улмаас хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 74.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан байна. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайлангийн тайлант үеийн үр дүн санхүүгийн байдлын тайланд дутуу бүртгэгдсэн байна.

Аудитаар залруулаагүй зөрчил илрээгүй байна.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөх зөрчил илрээгүй байна.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөх зөрчил илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БОЛОВСРУУЛСАН : АХЛАХ АУДИТОР

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЖАЛБАА

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

2025.02.10

2025.02.10

2025.02.10

